

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: “Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” УТҮГ
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: “Онцгой байдлын эрэн хайх, аврах цогцолборын зураг төсөл” (Бүс, аймаг, сумын түвшинд)
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: МУШС/20240103072
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: Үгүй
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 1,000,000,000.00 (Нэг тэрбум) төгрөг 2024 онд санхүүжих дүн: 1,000,000,000.00 (Нэг тэрбум) төгрөг
Б. АГУУЛГА	
ТШЗ 9.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: “Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” УТҮГ Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Жамьян гүний гудамж, Чандмань төвийн 3 давхар, 304 тоот Утасны дугаар: 51-262798 Цахим шуудангийн хаяг:
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: Үгүй
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.1	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл.
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”

<p>ТШЗ 16.1.2</p>	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: шаардана.</p> <ol style="list-style-type: none"> 1. Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ. Энэхүү тодорхойлолтыг ирүүлээгүй тохиолдолд тендер нээсэн өдрийн байдлаар татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн талаарх мэдээллийг шалгана. 2. Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөргүй хүчин төгөлдөр лавлагааг цахим системээс авч, зааварчилгааны дагуу цахим системээр холбогдох талбараар ирүүлнэ.
<p>ТШЗ 18.1</p>	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: Шаардана.</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 оны баталгаажсан санхүүгийн тайлантай байна. 2. Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 3 жилд буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна. 3. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна. 4. Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна.
<p>ТШЗ 18.2</p>	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тендерт оролцогчийн борлуулалтын орлогын мэдээллийг Сангийн яамны санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн систем дэх санхүүгийн тайлангаас шалгана. 2. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тодорхойлно. Үүнд: <ul style="list-style-type: none"> ✓ Тендерт оролцогчийн харилцагч банкны дансны үлдэгдэл; ✓ Харилцагч банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт /Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн тодорхойлолтыг тооцохгүй/; ✓ Судлагдаагүй зээлийн тодорхойлолтыг тооцохгүй. ✓ Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд.

	<p>3. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн” бус байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. (“Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй.</p>																																			
<p>ТШЗ 19.1</p>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: Шаардана.</p> <p>1. Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: Шаардана.</p> <table border="1" data-bbox="418 705 1430 1778"> <thead> <tr> <th data-bbox="418 705 479 858">№</th> <th data-bbox="479 705 732 858">Албан тушаал</th> <th data-bbox="732 705 862 858">Ажилтны тоо</th> <th data-bbox="862 705 1243 858">Боловсрол, мэргэжлийн ур чадвар</th> <th data-bbox="1243 705 1430 858">Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="418 858 479 1012">1.</td> <td data-bbox="479 858 732 1012">Ерөнхий инженер</td> <td data-bbox="732 858 862 1012">1</td> <td data-bbox="862 858 1243 1012">Иргэний ба үйлдвэрийн барилгын инженер</td> <td data-bbox="1243 858 1430 1012">6 жилээс доошгүй /Үндсэн ажилтан байх/</td> </tr> <tr> <td data-bbox="418 1012 479 1140">2.</td> <td data-bbox="479 1012 732 1140">Барилгын инженер</td> <td data-bbox="732 1012 862 1140">1</td> <td data-bbox="862 1012 1243 1140">Барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн инженер</td> <td data-bbox="1243 1012 1430 1140">3 жилээс доошгүй</td> </tr> <tr> <td data-bbox="418 1140 479 1293">3.</td> <td data-bbox="479 1140 732 1293">Архитектор</td> <td data-bbox="732 1140 862 1293">1</td> <td data-bbox="862 1140 1243 1293">Архитектор нь төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй байна</td> <td data-bbox="1243 1140 1430 1293">6 жилээс доошгүй /Үндсэн ажилтан байх/</td> </tr> <tr> <td data-bbox="418 1293 479 1446">4.</td> <td data-bbox="479 1293 732 1446">Дулааны инженер</td> <td data-bbox="732 1293 862 1446">1</td> <td data-bbox="862 1293 1243 1446">Дулааны хангамж, агаар сэлгэлтийн системийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх</td> <td data-bbox="1243 1293 1430 1446">3 жилээс доошгүй</td> </tr> <tr> <td data-bbox="418 1446 479 1600">5.</td> <td data-bbox="479 1446 732 1600">Ус хангамж, ариутгах татуургийн инженер</td> <td data-bbox="732 1446 862 1600">1</td> <td data-bbox="862 1446 1243 1600">Ус хангамж ариутгах татуургийн инженер эсвэл Халаалт агаар сэлгэлтийн инженер</td> <td data-bbox="1243 1446 1430 1600">3 жилээс доошгүй</td> </tr> <tr> <td data-bbox="418 1600 479 1778">6.</td> <td data-bbox="479 1600 732 1778">Цахилгааны инженер</td> <td data-bbox="732 1600 862 1778">1</td> <td data-bbox="862 1600 1243 1778">Цахилгааны инженер нь барилга байгууламжийн цахилгаан хангамжийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх</td> <td data-bbox="1243 1600 1430 1778">3 жилээс доошгүй</td> </tr> </tbody> </table>	№	Албан тушаал	Ажилтны тоо	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	1.	Ерөнхий инженер	1	Иргэний ба үйлдвэрийн барилгын инженер	6 жилээс доошгүй /Үндсэн ажилтан байх/	2.	Барилгын инженер	1	Барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн инженер	3 жилээс доошгүй	3.	Архитектор	1	Архитектор нь төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй байна	6 жилээс доошгүй /Үндсэн ажилтан байх/	4.	Дулааны инженер	1	Дулааны хангамж, агаар сэлгэлтийн системийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх	3 жилээс доошгүй	5.	Ус хангамж, ариутгах татуургийн инженер	1	Ус хангамж ариутгах татуургийн инженер эсвэл Халаалт агаар сэлгэлтийн инженер	3 жилээс доошгүй	6.	Цахилгааны инженер	1	Цахилгааны инженер нь барилга байгууламжийн цахилгаан хангамжийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх	3 жилээс доошгүй
№	Албан тушаал	Ажилтны тоо	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага																																
1.	Ерөнхий инженер	1	Иргэний ба үйлдвэрийн барилгын инженер	6 жилээс доошгүй /Үндсэн ажилтан байх/																																
2.	Барилгын инженер	1	Барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн инженер	3 жилээс доошгүй																																
3.	Архитектор	1	Архитектор нь төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй байна	6 жилээс доошгүй /Үндсэн ажилтан байх/																																
4.	Дулааны инженер	1	Дулааны хангамж, агаар сэлгэлтийн системийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх	3 жилээс доошгүй																																
5.	Ус хангамж, ариутгах татуургийн инженер	1	Ус хангамж ариутгах татуургийн инженер эсвэл Халаалт агаар сэлгэлтийн инженер	3 жилээс доошгүй																																
6.	Цахилгааны инженер	1	Цахилгааны инженер нь барилга байгууламжийн цахилгаан хангамжийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх	3 жилээс доошгүй																																

7.	Холбоо дохиолол, мэдээллийн инженер	1	Холбоо дохиолол, мэдээллийн инженер	3 жилээс доошгүй
8.	Төсөвчин	1	Төсөвчин	3 жилээс доошгүй
<p>2. Үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: шаардахгүй</p> <p>3. Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: Шаардана.</p> <p>Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд батлагдсан төсөвт өртөгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэгчээр ажилласан байна.</p> <p>4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: Шаардана.</p> <p>5. Бусад шаардлага: Шаардана.</p> <p>ТӨХ-д шаардсан мэдээллийг V бүлгийн маягтын дагуу ирүүлэхийг анхаарна уу.</p> <p>Маягт 5-ын дагуу үйлчилгээг үзүүлэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга</p> <ul style="list-style-type: none"> ✓ Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврыг гүйцэтгэх аргачлалын талаарх танилцуулга болон хэрэв ажлын даалгаврын талаар гаргах санал, зөвлөмж ирүүлнэ ✓ Тендерт шалгарч гэрээ байгуулсан оролцогч гэрээ байгуулсаны дараа цогцолборын макет загварыг ирүүлнэ. <p>Маягт 6. Үйлчилгээ үзүүлэх хуваарь</p> <ul style="list-style-type: none"> ✓ Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврын дагуу үзүүлэх үйлчилгээг гүйцэтгэх хуваарийг боловсруулж ирүүлнэ. Ажлын даалгаврын дагуу ажлын төлөвлөгөө, графикийг оновчтой төлөвлөсөн байх. 				
ТШЗ 19.2	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <p>1. Үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн шаардлагыг нотлох дараах баримт бичиг ирүүлнэ. Үүнд:</p> <p>а)Тендерт оролцогчийн үндсэн ажилтан, хөлсөөр ажиллах гэрээний дагуу ажиллах ажилтны мэдээллийг цахим систем дэх V бүлэгт</p>			

заасан маягтаар зааварчилгааны дагуу санал болгоно. Цахим системээр санал болгоогүй тохиолдолд хянан үзэхгүй. Цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсний нийлүүлэгчийн гарын авлага хэсгээс зааварчилгаатай танилцана уу.

б)Ажилтны сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй, төрийн мэдээлэл, солилцооны ХУР системээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. (Тендерт оролцогч нь Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia/-д ажилтны дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг урьдчилан шалгах шаардлагатайг анхаарна уу.) Хэрэв санал болгож буй ажилтан нь гадаад улсад сургууль төгссөн бол дипломын хуулбарыг орчуулгын хамт ирүүлнэ.

в)Тендерт оролцогчийн үндсэн ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг цахим системээр дамжуулан шалгана.

Нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн оролцогч төлдөггүй ажилтны хувьд хөлсөөр ажиллах гэрээг зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай.

- Ерөнхий инженер, Архитектор нь тухайн аж ахуйн нэгжид ажилладаг үндсэн ажилтан байх шаардлагатай бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийг 2024 оны 08, 09, 10 саруудад тендерт оролцогч тасралтгүй төлсөн болохыг “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгах тул НД-8 маягтаар гаргасан тайланг ирүүлэх шаардлагагүй.

г)Мэргэшсэн болон зөвлөх зэрэгтэй ажилтны хүчин төгөлдөр мэргэжлийн гэрчилгээний хуулбарыг тендерт хавсарган ирүүлнэ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.4-т заасан нийтийн албан тушаалтныг санал болгох тохиолдолд мөн хуулийн 18.5.3-т заасан удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийг хавсарган ирүүлнэ.

✓ Тухайн ажлын гэрээний гүйцэтгэлд дээрх санал болгосон ажилтнаас өөр ажилтнаар ажил гүйцэтгүүлсэн тохиолдолд илт худал мэдээлэл бүхий тендер гэж үзэн эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах нөхцөл болохыг анхаарна уу.

Тухайн инженер, техникийн ажилтны ажлын туршлагыг баталгаажуулахын тулд шаардагдсан жилийн нийгмийн даатгал төлсөн цахим тодорхойлолт ирүүлнэ. /Өөрийн E-Mongolia-с авсан цахим тодохойлолтыг ирүүлнэ/.

	<p>2. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох дараах баримт бичиг ирүүлнэ. Үүнд:</p> <p>а) Ижил төстэй ажлын туршлагын шаардлагыг хангах ажил гүйцэтгэсэн гэрээ ирүүлнэ.</p> <p>б) Магадлалын ерөнхий дүгнэлтийг ирүүлнэ.</p> <p>в) Захиалагчийн тодорхойлолт ирүүлнэ.</p> <p>3. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх дараах баримт бичиг ирүүлнэ. Үүнд:</p> <p>а)Тендерт оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан ажлын гүйцэтгэлийн явцын талаарх мэдээллийг тус тус ирүүлнэ.</p> <p>4. Ажлын даалгаврын дагуу ажлын төлөвлөгөө, графикийг оновчтой төлөвлөсөн байдлыг дараах байдлаар ирүүлнэ.</p> <p>а) Ажил гүйцэтгэх арга, аргачлал;</p> <p>б) Ажлын даалгаврын дагуу үзүүлэх үйлчилгээг гүйцэтгэх хуваарь;</p> <p>в) Инженер техникийн ажилтнуудын ажил үүргийн хуваарилалт;</p>
ТШЗ 19.2	<p>1. Ажил гүйцэтгэх үе шатны ажлын хуваарийг баталгаажуулан ирүүлэх ба ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь хуанлийн 90 хоног байна.</p> <p>2. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан зураг төсөл, техникийн нөхцөлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</p>

<p>ТШЗ 19.3</p>	<p>Тусгай зөвшөөрөл: Шаардана.</p> <p>-Барилга, хот байгуулалтын яамны:</p> <p>ЗТ-3.1. Дунд төвөгшилтэй төрөл бүрийн зориулалттай барилгын архитектур, барилга бүтээцийн зураг төсөл.</p> <p>ЗТ-6.1. Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл.</p> <p>ЗТ-6.2. Барилга байгууламжийн дотор халаалт, салхивч, хөргөлтийн систем гадна дулааны салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл.</p> <p>ЗТ-6.3. Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн систем, 35кВ хүртэлх гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл автомастикийн зураг төсөл.</p> <p>ЗТ-6.4. Барилга байгууламжийн дотор мэдээлэл холбоо, галын болон бусад дохиоллын системийн зураг төсөл, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл.</p> <p>ЗТ-10.2 Барилга байгууламжийн ажлын төсөв (Тухайн ажлын төрлийн хүрээнд)</p> <p>Уг ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн мэдээллийг Худалдан авах ажиллагааны цахим системээс шалгана. Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим системд бүртгэлтэй өөрийн зөвшөөрлийн талаар мэдээллийг бүрэн, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг шалгах үүрэгтэй.</p>
<p>ТШЗ 21.4</p>	<p>Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <i>Тохируулахгүй тогтмол байна.</i></p>
<p>ТШЗ 24.1</p>	<p>Тендерийн баталгааны дүн: 5,000,000.0 (таван сая) <i>төгрөг байна.</i></p>
<p>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</p>	
<p>ТШЗ 25.5</p>	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p>

	<p>1.Хуулийн 7 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлага хангасныг нотлох баримт бичиг.</p> <p>2.Тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан маягтын дагуу илгээсэн мэдээлэл</p> <p>3.Хуульд заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээлэл байгаа бол хууль зүйн үндэслэлийг тайлбарласан мэдэгдэл.</p>
ТШЗ 26.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2024 оны 12 дугаа сарын 06-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТШЗ 26.2	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 Минут</p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьян гүний гудамж, Чандмань төвийн 3 давхар, 304 тоот</p> <p>“Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” УТҮГ, 3 дугаар давхар, 304 тоот</p>
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 31.1	<p>Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: <i>Үгүй</i></p>
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 36.1	<p>Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <i>туйм</i></p>